



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/003/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг</p> <p>2025 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083 Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn	ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТТУВШИН ТАНАА
№ <u>2025.03.25</u> / <u>304</u>	
Танай _____ -ны № _____ -т	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, ижил шинж чанартай зардлыг төсөл хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын жагсаалтад давхардуулан төлөвлөсөн, төсвийн хөрөнгөөр ном, дуу бүтээсэн зэрэг нийт 890,139.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.6, 16 дугаар зүйлийн 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.10, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	
Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг	
<p>Орон нутгийн төсвийн орлогыг 64,935,924.3 мянган төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 81,614,924.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.</p>	
4625021606	

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сумын төсвийн хөрөнгөөр 584,618.3 мянган төгрөгийн өртөгтэй 4 км явган хүний зам байгуулж хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилтын хүрээнд 120 арга хэмжээг хэрэгжүүлэн 83.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		8,851.15	26,892.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	6,762.28	24,676.55
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	74.16	105.05
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,334.10	1,552.49
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	169.78	56.82
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	510.84	501.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		23,754.90	55,840.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	23,754.90	55,840.41
39200	Биет хөрөнгө		22,307.96	54,393.28
39300	Биет бус хөрөнгө	13	1,446.94	1,447.13
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		32,606.05	82,732.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		6,152.75	19,377.79
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	671.13	1,254.59
41300	Өглөг	17а, 17б	671.13	1,254.59
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,481.62	18,123.20
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	5,481.62	18,123.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		26,453.30	63,354.84
51	Засгийн газрын хувь оролцоо		26,453.30	63,354.84
51100	Засгийн газрын оруулсан капитал		6,215.71	6,215.71
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		350.99	350.99
51200	Хуримтлагдсан үр дүн		19,771.03	56,672.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		115.57	115.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		32,606.05	82,732.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		72,338.45	106,570.28
11	ТАТВАРЫН ОРЛОГО		51,277.74	72,308.89
110	Орлогын албан татвар		37,703.87	55,473.35
1100	Хувь хүний орлогын албан татвар		37,903.84	55,857.06
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(199.97)	(383.71)
113	Хөрөнгийн албан татвар		9,139.92	11,165.03
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,433.96	5,670.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	6,307.79	30,021.68
120	Нийтлэг татварын бус орлого		6,282.11	30,021.68
121	Хөрөнгийн орлого		25.68	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		14,752.92	4,239.71
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	64,703.75	62,061.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ		64,703.75	62,061.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,498.70	11,624.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		728.02	1,274.38

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91.61	160.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204.09	1,058.03
2104	Хангамж, бараа материалын зардал	1,733.88	630.91
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82.16	538.74
2107	Томилолт, зочны зардал	5.00	8.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760.98	1,184.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,892.96	6,768.89
212	ТАТААС	60.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,145.05	50,437.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,634.70	44,508.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,522.21	7,607.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,112.50	36,901.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	69,050.43	89,297.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,277.74	72,308.89
110	Орлогын албан татвар	37,703.87	55,473.35
1100	Хувь хүний орлогын албан татвар	37,903.84	55,857.06
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(199.97)	(383.71)
113	Хөрөнгийн албан татвар	9,139.92	11,165.03
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,433.96	5,670.52
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	396.76	564.69
1181	Газрын төлбөр	4,000.96	5,073.93
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	36.24	31.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,019.77	12,749.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,994.10	12,749.00
121	Хөрөнгийн орлого	25.68	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,752.92	4,239.71
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,818.49	63,030.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,818.49	63,030.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,590.74	9,292.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,294.20	2,182.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	266.09	323.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110.16	1,058.61
2104	Хангамж, бараа материалын зардал	942.77	1,166.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65.77	551.59
2107	Томилолт, зочны зардал	5.00	8.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,073.25	1,603.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,833.51	2,397.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,167.75	53,737.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,231.95	26,267.16
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,089.48	8,352.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,089.48	8,352.89
2200	Дотоод эх үүсвэрээр	3,089.48	8,352.89
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,089.48)	(8,352.89)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,142.46	17,914.27

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,619.82	6,762.28
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,762.28	24,676.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,340.81	-	20,340.81
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,340.81	-	20,340.81
9	Тайлант үеийн үр дүн	6,112.50	-	6,112.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,453.30	-	26,453.30
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,453.30	-	26,453.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,453.30	-	26,453.30
19	Тайлант үеийн үр дүн	36,901.54	-	36,901.54
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	63,354.84	-	63,354.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,722.16	17,445.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,272.47	9,289.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,220.79	5,839.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,285.12	1,188.28
210101	Үндсэн цалин	558.67	530.35
210102	Нэмэгдэл	493.69	488.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	182.28	135.46
210104	Урамшуулал	50.48	33.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149.04	149.04
210201	Тэтгэврийн даатгал	98.55	98.55
210202	Тэтгэмжийн даатгал	12.61	12.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	4.01	4.01
210204	Ажилгүйдлийн даатгал	9.27	9.27
210205	Эрүүл мэндийн даатгал	24.61	24.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,432.55	1,058.03
210301	Гэрэл, цахилгаан	305.15	228.18
210302	Түлш, халаалт	702.88	544.40
210303	Цэвэр, бохир ус	381.43	242.37
210304	Байрны түрээс	43.08	43.08
2104	Хангамж, бараа материалын зардал	626.92	622.92
210401	Бичиг хэрэг	28.29	27.83
210402	Тээвэр, шатахуун	47.49	47.21
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16.77	16.01
210404	Ном, хэвлэл	3.00	3.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480.00	480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51.38	48.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	553.74	553.15
210604	Урсгал засвар	553.74	553.15

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	9.30	7.96
210702	Дотоод албан томилолт	9.30	7.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,228.07	756.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,228.07	756.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,936.05	1,503.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,843.25	1,442.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	92.80	61.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,051.67	3,450.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,810.35	3,255.39
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,810.35	3,255.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	241.33	194.63
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68.41	25.45
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53.28	50.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47.19	46.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72.45	72.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,449.70	8,155.97
223001	Бусад хөрөнгө	11,449.70	8,155.97
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,722.16	17,390.86
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,297.30	3,154.53
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,297.30	3,154.53
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,850.58	14,220.14
320001	Орон нутгийн төсвөөс	18,850.58	14,220.14
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,024.28	16.20
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10.00	16.20
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,014.28	-
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	550.00	-
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	550.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,014.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	960.07
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	84	96
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
610001	Төсвийн байгууллага	6	6
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	45
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	15	16
620003	Үйлчлэх ажилтан	6	8
620004	Гэрээт ажилтан	9	12
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	45
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	17
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	8
650010	Гэрээт ажилтан	9	12
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,085.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985.74

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	891.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90.16
210104	Урамшуулал	90.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11.03
210201	Тэтгэврийн даатгал	7.69
210202	Тэтгэмжийн даатгал	0.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.83
210204	Ажилгүйдлийн даатгал	0.27
210205	Эрүүл мэндийн даатгал	1.38
2104	Хангамж, бараа материалын зардал	6.59
210401	Бичиг хэрэг	3.35
210402	Тээвэр, шатахуун	3.25
2107	Томилолт, зочны зардал	0.68
210702	Дотоод албан томилолт	0.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	783.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	782.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	40.14
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40.14
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	54.01
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	54.01
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	99.43
2200	Дотоод эх үүсвэрээр	99.43
223001	Бусад хөрөнгө	99.43
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,085.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,085.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	505.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	325.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	247.49

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 4,634.1 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 60,191.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн элэгдлийн зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн элэгдлийн зардалтай тулгах баталгаажуулахад 753.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Төсвийн тохируулга тайланд 4,573,168.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 550.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 326.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул "Өөрчлөлттэй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.1 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад 15.0 сая төгрөгөөр автомашины мотор худалдан авсан боловч капиталжуулж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд Цогтцэций сумын 100 жилийн ойг угтаж сумын тухай шинэ дуу бүтээлгэх арга хэмжээний зардал батлуулж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ", 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад зүүн бүсийн Эрчим хүчний салбарын урлаг, спортын арга хэмжээний зардалд 10.0 сая төгрөг, зүүн бүсийн сургуулийн багш, ажилчдын спортын арга хэмжээний зардалд 3.9 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,

зарцуулалтын нийтлэг журам"-ын 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

4. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад ЗДТГ-ын албан хаагч нар Сэврэй суманд зохион байгуулсан "Элсэн манханы баяр"-т оролцох зардалд 12.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

5. Тайлант онд Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа төлөвлөөгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.5-д "хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шийдвэрийн төсөлд хавсаргасан байх", 6.1-д "Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ", 6.2-д "Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

6. Төсөл, хөтөлбөрийн зардлыг түүвэрлэн шалгахад сумын 100 жилийн түүхэн номыг бүтээж хэвлүүлэх зардалд 120.0 сая төгрөг, 100 жилийн ойн нэвтрүүлэг бэлтгэх, шууд дамжуулах зардалд 90.0 сая төгрөгийг батлуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээ", 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

7. Үндэсний болон орон нутгийн онцлогтой спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр батлуулсан боловч тус зардлаас гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис,

шагайн харваа, сурын харваа зэрэг сумын аварга шалгаруулах тэмцээний зардлыг гарган зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Сумын ИТХ-ын 2024 оны 16/03 тогтоолын дагуу ХХОАТ, ТТАМТ, газрын төлбөр, хөрөнгө борлуулсаны орлого, малын албан татвар, нэр заагдаагүй орлогыг тус тус төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

2. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад сумын 100 жилийн ойн хандивын дансанд иргэд, ААН байгууллагаас орлого төвлөрүүлсэн, орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байхад нөөц хөрөнгийн зардлаас 80.0 сая төгрөгийг баяр наадмын үйл ажиллагаанд нэмж зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад Улаанбаатар хот, Өмнөговь аймаг, Цогтцэций суманд тус тус сар шинийн золголтын арга хэмжээ зохион байгуулж 58.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

4. Сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 16/03 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн тодотголоор "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт, их засвар, төсөл, арга хэмжээг" батлахдаа 50.0 сая төгрөгийн төсөвтэй Суманд шаардлагатай мэргэжлээр суралцагч нарыг дэмжих, оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, 50.0 сая төгрөгийн төсөвтэй Оюутан, залуучуудын хөгжлийг дэмжиж, оролцоонд тулгуурласан үйл ажиллагаануудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг давхардуулан тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 60,191,888.86 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	60.2			1	60.2	1	60.2				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн элэгдлийн зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн элэгдлийн зардалтай тулгах баталгаажуулахад 753,111.14 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	0.8			1	0.8	1	0.8				
Төсвийн тохируулга тайланд 4,573,168,897.50 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	4,573.2			1	4,573.2	1	4,573.2				
Дүн	3	4,634.1			3	4,634.1	3	4,634.1				

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад 15,000.000 төгрөгөөр автомашины мотор худалдан авсан боловч капиталжуулж бүртгээгүй	1	15.0			1	15.0								
2	Тайлант онд Цогтцэций сумын 100 жилийн ойг угтаж сумын тухай шинэ дуу бүтээлгэх арга хэмжээний зардал батлуулж, зарцуулсан	1	23.0			1	23.0								
3	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад зүүн бүсийн Эрчим хүчний салбарын урлаг, спортын арга хэмжээний зардалд 10,000.000 төгрөг, зүүн бүсийн сургуулийн багш, ажилчдын спортын арга хэмжээний зардалд 3,899.200 төгрөгийн дэмжлэгийг олгосон	1	13.9			1	13.9								
4	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад ЗДТГ-ын албан хаагч нар Сэврэй суманд зохион байгуулсан "Элсэн манханы баяр"-т оролцох зардалд 12,000.000 төгрөгийг зарцуулсан	1	12.0			1	12.0								
5	Тайлант онд Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа төлөвлөөгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй	1	0			1	0								
6	Төсөл, хөтөлбөрийн зардлыг түүвэрлэн шалгахад сумын 100 жилийн түүхэн номыг бүтээж хэвлүүлэх зардалд 120,000.000 төгрөг, 100 жилийн ойн нэвтрүүлэг бэлтгэх, шууд дамжуулах зардалд 90,000.000 төгрөгийг батлуулан зарцуулсан	1	210.0			1	210.0								

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Үндэсний болон орон нутгийн онцлогтой спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр батлуулсан боловч тус зардлаас гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, шагайн харваа, сурын харваа зэрэг сумын аварга шалгаруулах тэмцээний зардлыг гарган зарцуулсан	1	31.8			1	31.8					
8	Сумын ИТХ-ын 2024 оны 16/03 тогтоолын дагуу ХХОАТ, ТТАМТ, газрын төлбөр, хөрөнгө борлуулсаны орлого, малын албан татвар, нэр заагдаагүй орлогыг тус тус төсөвт бүрэн төвлөрүүлээгүй	1	55.7					1	55.7			
9	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад сумын 100 жилийн ойн хандивын дансанд иргэд, ААН байгууллагаас орлого төвлөрүүлсэн, орон нутгийн төсвөөс 100,000.000 төгрөгийн дэмжлэг олгосон байхад нөөц хөрөнгийн зардлаас 80,000.000 төгрөгийг баяр наадмын үйл ажиллагаанд нэмж зарцуулсан	1	80.0					1	80.0			
10	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад Улаанбаатар хот, Өмнөговь аймаг, Цогтцэций суманд тус тус сар шинийн золголтын арга хэмжээ зохион байгуулж 58,675.500 төгрөгийг зарцуулсан	1	58.7					1	58.7			
11	Сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 16/03 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн тодотголоор "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт, их засвар, төсөл, арга хэмжээг" батлахдаа 50,000.000 төгрөгийн төсөвтэй Суманд шаардлагатай мэргэжлээр суралцагч нарыг дэмжих, оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, 50,000,000 төгрөгийн төсөвтэй Оюутан, залуучуудын хөгжлийг дэмжиж, оролцоонд тулгуурласан үйл ажиллагаануудыг зохион байгуулах зэрэг ажлуудыг давхардуулан тусгасан	1	50.0					1	50.0			
Дүн		11	550.1			7	305.7	4	244.4			

Цогтцэций сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1									
	Дүн								
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1									
	Дүн								
	Нийт дүн						-		